



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 25-ны өдөр

Дугаар А/49

Эрдэнэт

Хувийн хамгаалах хэрэгсэл, нэг удаагийн  
эмнэлгийн хэрэгсэл хандив тусламжаар  
олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.1.4, Иргэний хуулийн 276.5 дах заалт, 2020 оны 02 сарын 05 өдрийн Улсын онцгой комиссын 3-р хурлын тэмдэглэлийн 1.2, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 сарын 22 өдрийн 19-р албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шинэ төрлийн коронавирус Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах ажлын хүрээнд Монгол-Оросын хамтарсан Улаанбаатар төмөр зам ХХК-ны Дархан татах хэсгийн Эрдэнэт депогийн ажилчид, албан хаагчдад хандив, тусламжаар олгох хувийн хамгаалах хэрэгсэл, нэг удаагийн эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг нэгдүгээр, олгосон барааны зарцуулалтын тайлангийн маягыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрдэнэт өртөөний ажилчид, албан хаагчдад олгох нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн олголт, бүрэн бүтэн байдал, зарцуулалтын тайланд хяналт тавихыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т, хандиваар өгөх барааг бэлдэх, баримтжуулахыг нярав /Л.Даваажав/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилт болон гэрээний хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХ мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

ЭМГ-ын даргын 2020 оны 01.р сарын 21-ны  
...өдрийн 11 р тушаалын нэгдүгээр хавсралт



ХАНДИВ ТУСЛАМЖААР ОЛГОХ НЭГ УДААГИЙН ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,  
ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Эмнэлгийн хэрэгслийн нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Халуун хэмжигч	1	130,000	130,000
2	Амны хаалт /нэг удаагийн/	100	800	80,000
3	Халад /цагаан/	50	2,800	140,000
4	Нүүрний хаалт	10	4,950	49,500
5	Улавч	50	100	5,000
6	Комбинзон	10	12,000	120,000
7	Нэг удаагийн малгай	50	130	6,500
8	Бээлий	100	160	16,000
	Нийт			547,000

Төлөвлөлт гаргасан: ЭБХЧАБЗХХМ

О.Анхбаяр

Хянасан: ЭМГ-ын нягтлан бодогч

Н.Чулуун-Эрдэнэ

Хүлээн авсан: